



MONGOLIAN

Эргэн суурьших дэмжлэг

ОУШХБ-аас төлбөр хийх тухай тайлбар



IOM International Organization for Migration  
OIM Organisation internationale pour les Migrations  
IOM Internationale Organisation für Migration

- Эх орондоо буцсанаас хойш **3 сарын дотор** Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагын (ОУШХБ) Монгол дахь салбартай холбоо барих ёстой.
- ОУШХБ дээр ирж уулзахдаа паспорт, иргэний үнэмлэх зэрэг **биеийн байцаалтаа** үзүүлж, өөрийн биеэр ирсэнийг баталгаажуулах ёстой.
- Зорин очиж буй улсдаа хуулийн дагуу оршин суух эрхтэй хүндэргэн суурьших мөнгөн тэтгэлэг олгогдоно. (гуравдагч оронд оршин суух хүсэлтэй бол танд оршин суух эрх, хөдөлмөр зөвшөөрөл шаардагдана гэдгийг анхаарна уу).
- Хэрвээ та бизнес эрхлэхээр шийдсэн бол таны явуулах үйл ажиллагаа **хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа** байхаас гадна та **хэрэгцээтэй зөвшөөрлийг** зохих байгууллагаас авч, үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн гэрчилгээний хуулбарыг ОУШХБ-т өгөх ёстой.
- Та эргэн суурьших төслийг хэрэгжүүлэхдээ ОУШХБ-ын ажилтантай хамтран ажиллах ёстой.
- Эргэн суурьшихад үзүүлэх дэмжлэгийн мөнгийг эх орондоо эргэн ирсэн өдрөөс эхлэн нэг жилийн дотор хэрэглэж дууссан байх ёстойг анхаарна уу. (Шилжих Хөдөлгөөний Хэрэг Эрхлэх Газар (ШХХЭГ) онцгойлон зөвшөөрснөөс бусад тохиолдолд).
- Төслийн санааг сольсон бол төлбөр хийгдэхээс өмнө заавал зөвшөөрөл авсан байх шаардлагатай.
- Танд олговол зохих мөнгөн тусламжийн дээд хэмжээг гэрээнд заасан бөгөөд таны авсан бараа үйлчилгээний худалдан авалтыг гэрчлэх санхүүгийн баримтыг үндэслэн гэрээнд заагдсан мөнгөн дүнд багтаан ШХХЭГ, донор байгууллагаас хэдий хэмжээний тусламж үзүүлэх талаар зөвшөөрөл олгож, тусламж болгон олгох болно.
- ШХХЭГ, донор байгууллагын олгохоор зөвшөөрсөн хэмжээний төлбөрийг бага багаар таслан хийж болно.
- Төлбөрийг бараа худалдаж буй, үйлчилгээ үзүүлж буй **бэлтгэн нийлүүлэгч, үйлчилгээний байгууллага** (түрээслэх эд хөрөнгийн эзэн, эмийн сан зэрэг) руу банкны бэлэн бус гүйлгээгээр хийнэ.
- Бэлтгэн нийлүүлэгч, үйлчилгээний байгууллагад төлбөрийг шууд хийх боломжгүй тохиолдолд та өөрийн мөнгөөр худалдан авалтыг хийсний дараа төлбөр хийсэн санхүүгийн баримтанд үндэслэн танд нөхөн олгож болно.
- Бэлэн мөнгөөр ямар ч төлбөр хийхгүй болохыг анхаарна уу.
- Төлбөрийг ихэвчлэн үндэсний мөнгөн тэмдэгтээр хийдэг бөгөөд **швейцари франкаар** төлбөр хийхгүй болохыг анхаарна уу
- Тусламж болгон олгох тэтгэмжийн хэмжээг жил бүр ШХХЭГ -аас америк доллортой харьцуулан тогтоодог.
- ОУШХБ-аас валют хөрвөөх ханш сар бүр шинэчлэгдэн гарч байдаг бөгөөд энэхүү ханшаар тэтгэлгийн мөнгийг олгоно.

#### Харилцах/ холбоо барих

- **Буцахаас өмнө:** ОУШХБ-ын Монгол дахь салбартай шууд холбоо тогтоохгүй, буцаах асуудал эрхлэх ажилтан Швейцари улсад байхад чинь байнга уулзаж туслаж байх болно.
- **Эх орондоо буцсаны дараа:** ОУШХБ-ын Монгол дахь салбар таны бүх асуултанд хариулж, төсөл хэрэгжүүлэхэд туслах үүрэгтэй. ( Швейцари улсад байгаа, буцаах асуудал эрхлэх ажилтан туслах боломжгүй)